

БАТЛАВ:
"БИДИСЕК" ХК
Б.ЛХАГВАДОРЖ
ТУЗ-ИЙН ДАРГА

2014 оны 06 сарын 04 -ны өдөр

33

ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЗӨВЛӨХИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ ДОТООД ЖУРАМ

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

- 1.1 Энэ журмын зорилго нь Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд заасан хөрөнгө оруулалтын чиглэлээр зөвлөгөө, мэдээлэл өгөх үйлчилгээ /цаашид "хөрөнгө оруулалтын зөвлөх үйлчилгээ" гэх/-ний нэр төрөл, энэхүү үйлчилгээнд оролцогчдын эрх үүргийг тодорхойлохтой холбогдсон харилцааг зохицуулахад оршино.
- 1.2 Хөрөнгө оруулалтын зөвлөхийн үйлчилгээ эрхлэгч нь энэхүү үйлчилгээнд холбогдох хууль тогтоомж, эрх бүхий байгууллагаас батлагдсан журам, зааврыг мөрдлөг болгоно.
- 1.3 Хөрөнгө оруулалтын зөвлөх үйлчилгээ эрхлэгч нь үйлчлүүлэгчийн эрх, ашиг, хүсэл сонирхолд нийцүүлж, нийтэд танилцуулагдсан мэдээлэл дээр үндэслэн судалгаа шинжилгээ хийх, зах зээлийн үнэ, үнийн өсөлт, эдийн засгийн үр ашиг зэргийг тооцоолж төлбөртэйгээр зөвлөгөө, мэдээллийн үйлчилгээ үзүүлнэ.

ХОЁР. БАРИМТЛАХ ЗАРЧИМ

- 2.1 Хамтран ажиллах гэрээнд тусгагдсан үйлчлүүлэгчийн мэдээллийн нууцыг хадгалах;
- 2.2 Харилцагчид өгөх зөвлөгөөг бие даасан, хараат бус байдлаар боловсруулах;
- 2.3 Хууль тогтоомжийн хүрээнд зөвлөгөө, мэдээлэл өгөх;

- 2.4 Үүсч болзошгүй эрсдэлийн талаар үйлчлүүлэгчид шуурхай мэдээлэх;
- 2.5 Зөвлөх үйлчилгээний судалгаа, шинжилгээг зах зээлийн бодит тоо баримтанд тулгуурлан гүйцэтгэх;

ГУРАВ. ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТӨРӨЛ

- 3.1 Хөрөнгө оруулалтын зөвлөхийн чиглэлээр зөвлөгөө, мэдээлэл өгөх үйлчилгээнд дор дурдсан үйлчилгээний төрлүүд хамаарна.
- 3.2 Арилжаанд оролцогч иргэд, аж ахуй нэгж байгууллагуудад хөрөнгө оруулалтын зөвлөх үйлчилгээг дараах чиглэлээр өгч ажиллана.
 - 3.2.1 Санхүүжилт татан төвлөрүүлэх зөвлөгөө өгөх;
 - 3.2.2 Үнэт цаасны хөрөнгө оруулалт;
 - 3.2.3 Дотоодын зах зээлийн судалгаа, шинжилгээ;
 - 3.2.4 Дотоодын хөрөнгө оруулалтын үйл ажиллагаанд зуучлах;
 - 3.2.5 Хөрөнгө удирдлага;
- 3.3 ААН-д үзүүлэх Байгууллагын зөвлөх үйлчилгээнд дараах төрлүүд хамаарна.
 - 3.3.1 Хувьцаа эзэмшигчдийн ээлжит болон ээлжит бус хурлыг зохион байгуулах;
 - 3.3.2 Үнэт цаасны арилжаа сэргээх;
 - 3.3.3 Тендер санал зарлах;
 - 3.3.4 Компанийн хэлбэрийг өөрчлөх;
 - 3.3.5 Хөрөнгийн зах зээл дээрээс санхүүжилт татах;
 - 3.3.6 Компанийн тухай хууль, эрх зүйн зөвлөгөө;

ДӨРӨВ. ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ШААРДЛАГА

- 4.1 Тус үйлчилгээнд Санхүүгийн зохицуулах хорооны 2014 оны 07 дугаар тогтоолоор батлагдсан "Үнэт цаасны зах зээлийн зохицуулалттай этгээдийн үйл ажиллагааны журам"-д заасан шаардлагаас гадна зөвлөх мэргэжилтэн нь Санхүүгийн зохицуулах хорооноос үнэт цаасны зах зээл дээр ажиллах

эрх авсан, 2-оос доошгүй жил үнэт цаасны зах зээлд ажилласан туршлагатай байх шаардлага тавигдана.

4.2 Хөрөнгө оруулалтын зөвлөхийн үйлчилгээ эрхлэгч болон үйлчлүүлэгч талууд харилцан тохиролцсоны үндсэн дээр гэрээг байгуулна. Гэрээнд дараах зүйлсийг заавал тусгасан байна.

4.2.1 Үйлчлүүлэгч нь иргэн бол түүний овог нэр, регистрийн дугаар, хаяг, утас, хуулийн этгээд бол хуулийн этгээдийн нэр, улсын бүртгэлболон регистрийн дугаар, хаяг, утас;

Гэрээний хугацаа,;

4.2.2 үйлчилгээний төрөл, чиглэл;

4.2.3 Талуудын эрх, үүрэг, хүлээх хариуцлага;

4.2.4 Төлбөрийн нөхцөл;

4.2.5 Мэдээллийн нууцлал;

4.2.6 Гэрээ хүчин төгөлдөр болох, цуцлах үндэслэл;

4.2.7 Бусад;

4.3 Хөрөнгө оруулалтын зөвлөхийн үйлчилгээ эрхлэгч нь үйлчлүүлэгч бүрт хувийн хэрэг нээж хөтлөх бөгөөд түүнд гэрээ, төлбөр тооцооны баримт, ашигласан мэдээлэл болон үйлчилгээ үзүүлэхтэй холбогдуулан боловсруулсан баримт бичгийг хавсаргана.

ТАВ. ҮЙЛЧЛҮҮЛЭГЧИЙН ЭРХ, ҮҮРЭГ

5.1 Үйлчлүүлэгч нь дараах эрх, үүрэгтэй:

5.1.1 Хөрөнгө оруулалтын зөвлөхийн үйлчилгээ эрхлэгчийн санхүүгийн болон ерөнхий мэдээлэлтэй танилцах;

5.1.2 Мэргэжилтний танилцуулга, ажлын туршлага зэрэг мэдээлэлтэй танилцах;

5.1.3 Гэрээнд заасан хугацаанд үйлчилгээг бүрэн авах;

5.1.4 Үйлчилгээний талаар гомдол, санал гаргах;

5.1.5 Гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах, цуцлах тухай санал гаргах;

5.1.6 Шаардлагатай гэж үзсэн мэдээллийг хөрөнгө оруулалтын зөвлөхийн үйлчилгээ эрхлэгчид үнэн зөв гаргаж өгөх;

ЗУРГАА. ҮЙЛЧИЛГЭЭ ЭРХЛЭХ “БИДИСЕК” ҮЦК-ИЙН ЭРХ, ҮҮРЭГ

- 6.1 Хөрөнгө оруулалтын зөвлөхийн үйлчилгээ эрхлэгч нь дараах эрх үүрэгтэй:
- 6.1.1 Харилцагчийн хөрөнгө оруулалтын туршлагын талаар мэдээлэл авах;
 - 6.1.2 Харилцагчийн санхүүгийн нөхцөл байдал, хөрөнгө оруулалт хийх хэмжээ зэрэг мэдээлэл авах;
 - 6.1.3 Үйлчилгээ үзүүлэхтэй холбоотойгоор үйлчлүүлэгчийн зөвшөөрлийг үндэслэн гуравдагч этгээдийг оролцуулах;
 - 6.1.4 Үйлчилгээ үзүүлэхтэй холбогдох баримт бичгийг үйлчлүүлэгчээс шаардах;
 - 6.1.5 Аливаа маргааны талаар шүүхэд нэхэмжлэл гаргах;
 - 6.1.6 Үйлчлүүлэгчтэй гэрээ байгуулж ажиллах;
 - 6.1.7 Гэрээгээр хүлээсэн үйлчилгээг заасан хугацаанд бүрэн үзүүлэх;
 - 6.1.8 Хууль тогтоомжийн хүрээнд зөвлөгөө мэдээлэл өгөх зарчмыг баримтлах;
 - 6.1.9 Үйлчилгээ үзүүлсэн талаар тодорхой, үнэн зөв бүртгэл хөтлөх;
 - 6.1.10 Үйлчлүүлэгчийн нууцыг чандлан хадгалах;

**ДОЛОО. ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭНД ХОРИГЛОХ
ЗҮЙЛС**

- 7.1 Хөрөнгө оруулалтын зөвлөхийн үйлчилгээ эрхлэгчид дараах зүйлсийг хориглоно:
- 7.1.1 Энэхүү журмын 3 дугаар зүйлд зааснаас бусад чиглэлээр зөвлөгөө, мэдээлэл өгөх;
 - 7.1.2 Үйлчлүүлэгчийг хуурамч, буруу, дутуу мэдээллээр хангах, төөрөгдүүлэх;
 - 7.1.3 Өөрийн болон гуравдагч этгээдийн ашиг сонирхолд нийцүүлэн мэдээллийг нуун дарагдуулах, гуйвуулах;

7.1.4 Үйлчлүүлэгчийн нууцад хамаарагдах мэдээллийг бусдад задруулах, тараах;

7.1.5 Гэрээнд заасан үйлчилгээнд үл хамаарах мэдээллийг үйлчлүүлэгчээс шаардах;

НАЙМ. ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТӨЛБӨР

8.1 Үйлчлүүлэгч нь иргэн бол үйлчилгээний хураамж нь цагийн 10,000 төгрөг байна.

8.1.1 Дансанд хийгдэх гүйлгээний хэмжээнээс хамааран энэхүү хураамжийг зөвлөгч, үйлчлүүлэгчтэйгээ зөвшилцөн тогтоож болно.

8.2 Үйлчлүүлэгч нь хуулийн этгээд бол "Байгууллагын зөвлөх үйлчилгээ"-г авах бөгөөд үйлчилгээний төлбөрийг дор дурдсан зүйлсийг харгалзан, үйлчлүүлэгчтэй тохиролцсоны үндсэн дээр ямар хэлбэрээр төлөх зэргийг гэрээнд тусган зохицуулна.

8.2.1 Тухайн үйлчлүүлэгчид шаардлагатай үйлчилгээний төрөл;

8.2.2 Шаардагдах цаг хугацаа;

ЕС. ХАРИЛЦАГЧДАД МЭДЭЭЛЭЛ ХҮРГЭХ

9.1 Хөрөнгө оруулалтын зөвлөх мэргэжилтэн нь үйлчлүүлэгчид дараахь мэдээллүүдийг гэрээний хүчинтэй хугацаанд илгээж байна:

9.1.1 Зах зээлийн судалгаа шинжилгээ;

9.1.2 Үнэ ханшийн мэдээ, мэдээлэл;

9.1.3 Бусад гэрээний дагуу өгөх мэдээ, мэдээллүүд

АРАВ. ХАРИЛЦАГЧИЙН МЭДЭЭЛЛИЙГ ШАЛГАХ

10.1 Арилжаанд оролцогчидод Хөрөнгө оруулалтын зөвлөхийн үйлчилгээ үзүүлэх гэж байгаа бол дараах мэдээллийг бэлтгэж, шалгасан байна.

10.1.1 Тухайн харилцагчийн дансны төлөв байдлыг тодорхойлох;

10.1.2 Багц бүрдүүлэлтийн талаарх мэдээлэл;

10.1.3 Хувьцаат компаниудын судалгаа;

3

- 10.1.4 Ханшийн судалгаа;
- 10.1.5 Хөрөнгийн зах зээлийн судалгаа;
- 10.2 Байгууллагын зөвлөх үйлчилгээ үзүүлэх гэж байгаа бол дараах мэдээллийг бэлтгэж, шалгасан байна;
 - 10.2.1 Тухайн компанийн нөхцөл байдалтай танилцаж, дүгнэлт гаргасан байх;
 - 10.2.2 Хийгдэх ажлын жагсаалт, шаардлагатай материалуудын жагсаалт гаргах;
 - 10.2.3 Компанийн дүрэм, холбогдох хууль, журам;
- 10.3 Харилцагч дээр дурдсан мэдээллийг өгөхөөс татгалзсан тохиолдолд Зөвлөх нь хөрөнгө оруулалтын зөвлөх үйлчилгээг үзүүлэхээс татгалзана.

АРВАН НЭГ. ХЯНАЛТ, ХАРИУЦЛАГА

- 11.1 Хөрөнгө оруулалтын зөвлөх үйлчилгээ эрхлэгч ҮЦК нь зөвлөх мэргэжилтний үйл ажиллагаанд хяналт тавих, гарч болох эрсдэлийг тодорхойлох, түүнээс урьдчилан сэргийлэх, үүрэгт ажлаа хууль тогтоомжийн дагуу хийж байгаа эсэхэд дүгнэлт хийх, хариуцлага тооцох зэрэг асуудлыг "Дотоод хяналтын журам"-р зохицуулна.